


<https://doi.org/10.69561/mjac.v25i49.3840>

Article | Fasc.15

## Хийлийн зохиолыг боловсруулан хөгжимдөх асуудалд

**Баттогтохын Номуунаа**  

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс  
 nomuunaa.violinist@gmail.com

**Баянжаргалын Оюунбадрах**  


Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс

**Хураангуй:** Хийлийн зохиолыг боловсруулан хөгжимдөхөд хөгжмийн боловсруулга, хөгжмийн илэрхийллийн аргууд, мөн хөгжимдөх ур зүй салшгүй холбоотой юм. Хөгжимчин юу илэрхийлэхийг хүсэж байгааг бодит болгон харуулах, сонсуулах боломжийг хөгжмийн тайлбарлалаар бий болгодог. Гэхдээ хөгжимчний сайхан зохиол бүтээл хөгжимдөх хүсэл эрмэлзэл, сэтгэл, мэдрэмж байгаад ур чадвар муу байвал хөгжмийн тайлбарлал амжилтгүй болох болно. Хөгжимчид хэрхэн сайн хөгжимдлөг бий болгох вэ? гэх асуудлын арга замыг бүтээлч байдлын хүрээнд эрэлхийлсээр байдаг тул ур чадвараа хөгжүүлэх, мөн хөгжмийн тайлбарлалд зайлшгүй шаардагдах боловсруулгын аргуудыг сайтар эзэмших шаардлагатай байдаг. Тиймээс хөгжмийн тайлбарлалд нөлөөлөгч хүчин зүйл болох боловсруулгын талаар судлаач нарын өгүүлэл, докторын диссертац, хийлч Ц.Мөнхболд болон судлаачийн /өгүүлэл бичигчийн/ өөрийн хөгжимдөх аргачлал, боловсруулгыг харьцуулан судаллаа.

**Түлхүүр үгс:** *боловсруулга, хуваарилал, хэллэг, хөгжимчин*

## Problems of music editing and expression of the violin composition

**Nomuunaa Battogtokh**  

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia  
 nomuunaa.violinist@gmail.com

**Oyunbadrakh Bayanjargal**  

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia

**Abstract:** Music editing, music expression methods and music etiquette are inextricably linked to the editing of violin compositions. Music interpretation creates the opportunity to show and listen to what the musician wants to express. However, if the

musician's desire, heart, and feeling to make music are good, the music interpretation will not be successful. How can musicians make good music? As the solution to the problem is still being sought within the framework of creativity, it is necessary to develop skills and master the editing methods that are essential for interpretation. Therefore, about edition, which is an influential factor in music interpretation, researchers' articles and doctor's work, violinist Ts. Munkhbold and the essay writer's own music-making methods and processing were compared.

**Keywords:** *edition, fingering, articulation, musician*

### Оршил

Аливаа зохиол бүтээлийн хөгжимдлөгт боловсруулга хийх хэрэгцээ нь хөгжимчдөд зайлшгүй тохиолддог. Тодруулбал, хөгжмийн зохиолыг эгшиглүүлэхийн тулд өөрийн ур чадвартаа нийцүүлэн хөгжмийн илэрхийллийн аргуудаар боловсруулга хийн, бүтэн цогц бүтээл бий болгох буюу хөгжмийн тайлбарлал бий болох чухал үүргийг хөгжимчин гүйцэтгэж байдаг.

Боловсруулга нь боловсруулагч, хөгжимчний хөгжмийн тайлбарлалыг дамжуулах арга, илэрхийлэл юм. Тиймээс бид хөгжимчний хөгжимдлөгөөр дамжин хүний сэтгэлд хүрч, мэдрэгдэж буй тэрхүү мэдрэмж нь угтаа боловсруулгын аргаар дамжин хөгжимчний сэтгэлгээгээр баяжин хөгжмийн тайлбарлалыг илэрхийлж байгаа үйл явц гэж үзэж байна. Хөгжмийн тайлбарлалыг илэрхийлэхийн тулд юун түрүүнд зохиолтой танилцан хөгжимдлөгт зориулж боловсруулга хийдэг. Боловсруулга нь хөгжмийн илэрхийллийн аргуудаар эх бичвэрт тэмдэглэгдэн үлдэх бол, хөгжмийн тайлбарлал нь боловсруулгыг хөгжимчний тухайн цаг үед төрж буй мэдрэмж, бодол, сэтгэл хөдлөл, сэтгэлгээгээр дамжуулан эгшиглүүлж буй үйл явц юм. Аливаа зохиолыг эгшиглүүлэхийн өмнө эхлээд боловсруулаад, дараа нь хөгжимдлөгөөр дамжуулан бүтээлч үйл явцын хүрээнд хөгжмийн тайлбарлалыг бий болгож байдаг.

### Судалгааны арга зүй

Эх хэрэглэгдэхүүн цуглуулах, судалгааны мэдээлэлд боловсруулалт хийх, задлан шинжлэх, харьцуулах, нэгтгэн дүгнэх, ажиглалт, оролцооны ерөнхий аргуудаас гадна хөгжмийн зохиолыг боловсруулах аргуудыг сонгон хэрэглэсэн болно.

### Судалгааны үр дүн

Б.Оюунбадрах боловсруулгын талаар дараах байдлаар тодорхойлжээ. Хөгжмийн зохиолыг боловсруулах нь хөгжмийн зохиолчийн муу зохиолыг хөгжимчний зүгээс сайжруулах тухай ойлголт биш, харин хөгжмийн зохиолыг эгшиглүүлэхийн тулд хөгжимчин – боловсруулагчийн зайлшгүй хийдэг боловсруулах үе шат юм. Хөгжмийн зохиол нь хөгжим зохиох – боловсруулах – хөгжимдөх үе шатуудад жинхэнэ утгаараа боловсрон хэлбэржиж олон нийтэд хүрдэг. Хөгжим судлалын ухаанд боловсруулга гэдэг ойлголт нь тухайн салбарын мэргэжилтэн боловсруулаад, хөгжимдөхөд бэлэн болсон зохиол юм. Хөгжмийн боловсруулагч нь юуны өмнө судлаач – хөгжимчид байдаг. Учир нь хөгжмийн

зохиолыг боловсруулна гэдэг нь тухайн зохиолыг хэрэглээнд оруулахад /судлах, хөгжимдөх, олны хүртээл болгох/ бэлдэх асуудал юм. Хөгжмийн боловсруулгыг дан ганц мэргэжлийн боловсруулагч хийдэг гэж үзэх нь өрөөсгөл юм. Хөгжмийн зохиолч хөгжмөө туурвих, хөгжимчин түүнийг нь хөгжимдөх явцдаа өөрсдийн боломжоор хөгжмийн зохиолыг боловсруулдаг (Оюунбадрах 2016, 13) гэжээ.

Л.Булгакова хөгжмийн боловсруулга болон боловсруулагчийн тухай "...Боловсруулгын асуудал нь хөгжим судлалд бага судлагдсан зүйлсийн нэг юм. Боловсруулагч нь хөгжмийн зохиолчийн хөгжмийг судлан, ноот бичвэрт дүн шинжилгээ хийж, хөгжмийн зэмсгүүдийн онцлогт тохируулан, цаг үеийн шаардлагад нийцүүлэн боловсруулдаг. Боловсруулга нь боловсруулагчийн тайлбарлалыг дамжуулах арга юм..." (Булгакова 2006, 246, 248) гэж дүгнэсэн байдаг. Тэрээр боловсруулгын хэлбэрүүдийг:

1. Боловсруулагчийн тэмдэглээг хөгжмийн зохиолчтой адил байдлаар оруулах
2. Боловсруулагчийн тэмдэглээг хөгжмийн зохиолчоос ялгаж оруулах
3. Тэмдэглээ нь хавсралтад байрлах
4. Зарим тэмдэглээг хөгжмийн текстэд оруулж, үлдсэнийг эшлэл зүүлтээр байрлуулах гэж ангилсан.

Ф.Виеринг ба бусад "...Боловсруулагчийн үүрэг бол уг зохиолын эх бичвэрийг хүлээн зөвшөөрөгдсөн аргаар боловсруулах явдал юм. Энэ нь эх бичвэрийг боловсруулж, орчин үеийн хөгжимдөх ур чадварт нийцүүлэн тохируулах буюу хөгжимдөхөд хялбар болгодог. Өөрөөр хэлбэл, алга болсон мэдээллээр хангаж, ойлгомжгүй байдлыг шийдэж, чухал эсвэл хэцүү хэсгүүдийг боловсруулснаар хөгжимдөхөд эвтэйхэн болгодог гэсэн үг юм..." (Виеринг 2009, 6) гэж тайлбарлажээ.

Дээрх судлаачдын бүтээлүүдийг нэгтгэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. **Хөгжмийн зохиолыг боловсруулах** нь тухайн зохиолыг хэрэглээнд оруулахад бэлдэх /судлах, хөгжимдөх, олны хүртээл болгох/ асуудал юм.
2. **Боловсруулгын үүрэг** нь эх бичвэрт хөгжмийн тайлбарлалыг хөгжимдөх ур чадварт нийцүүлэн тэмдэглэх юм.
3. **Боловсруулагчийн үүрэг** нь зохиолыг судлан, хөгжмийн зэмсгийн онцлогт тохируулж, хөгжимдөхөд эвтэйхэн боловсруулга хийх юм.

А.Благая (2014) хийл хөгжимд зориулсан бүтээлүүд ихэвчлэн өмнөх үеийн хийлчдийн боловсруулга хэлбэрээр хэрэглэгддэг бөгөөд ямар боловсруулгыг сонгох нь хөгжимчний хөгжимдөх ур чадвар болон түүний урын сантай чухал холбоотой гэж бичжээ. Харин Т.Мустакимов (2021) энэ талаар хөгжим сонсголын урлаг болохын хувьд огторгуйд байдаггүй, харин цаг хугацааны хувьд л оршдог. Урлаг биднээс төгс төгөлдөрт хүрэн хүртлээ тэмцэх, дадлага сургуулилт хийхийг шаарддаг ч хүлээн зөвшөөрөгдсөн хөгжимдлөгийн эрэл хайгуул дуусдаггүй бөгөөд төгс төгөлдөрт хүрч чаддаггүй. Эцсийн хөгжмийн тайлбарлалыг эрэлхийлэх нь хязгааргүй үргэлжлэх ба хэзээ ч дуусдаггүй гэжээ. Энэ нь хөгжимчний ур чадвар болон боловсруулгын аргаас шалтгаалан хөгжмийн тайлбарлалыг илэрхийлэх байдал харилцан адилгүй тул хөгжимчид байнга суралцаж, мэдлэгээ тэлэх хэрэгтэй байдаг гэдгийг хэлжээ.

Мөн Т.Леджер "...Хөгжим бодит байдалд оршихын тулд хөгжимчдийг

шаарддаг. Хөгжим бол бүтээлч үйл явц бөгөөд зөвхөн логик төдийгүй хөгжмийн тайлбарлалыг шаарддаг...” (Леджер 2020, 18) гэжээ. Тэрээр судалгаа шинжилгээнд семиотик суурийг ашиглах давуу тал нь үйл явцын түвшин бүрд объектив ба субъектив нөхцөл байдлыг авч үзэх чадвар юм. Үүний зорилго нь шинэ сэтгэлгээ, дүн шинжилгээ хийх биш харин хөгжмийн хийсвэр, бүтээлч элементүүдийг судлах боломжийг олгох семиотик шинжилгээний хүрээг танилцуулах явдал юм. Онолын хувьд анализ хийх, хөгжимчний зөн совингийн дагуу илрэх хөгжмийн шийдвэрийг ойлгохыг хэлнэ гэж үзсэн байдаг.

Дээрх судлаачдын дүгнэлтээс хөгжмийн тайлбарлал нь бүтээлч үйл явц бөгөөд боловсруулгаар илэрхийлэгдэнэ. Боловсруулга хийхэд хөгжимчний ур чадвар чухал тул дадлага сургуулилтыг шаардаж байдаг талаар харж болохоор байна.

Дээрхээс үзэхэд, хөгжимчний боловсруулга нь бүтээлч үйл ажиллагаа юм. Учир нь хөгжимчин хөгжмийн зохиолыг боловсруулахдаа түүнд дүн шинжилгээ хийж, хэрхэн хөгжимдөхөд эвтэй болон сайхан эгшиглүүлэх зэрэгт хөгжмийн илэрхийллийн аргуудаар боловсруулга хийн, үүнийгээ хөгжимчний сэтгэлгээ, мэдрэмжээр дамжуулан хөгжмийн тайлбарлалыг бий болгож байдаг.

Сэтгүүлч Максим Рейдер, гарамгай хөгжимчин Евгений Кисинтэй төгөлдөр хуурчийн хөгжмийн тайлбарлалын талаарх бодлыг онцолсон ярилцлага хийсэн байдаг. Уг ярилцлагыг тодруулбал:

- М.Р: Та шинэ бүтээлээ хэрхэн бэлддэг вэ?
- Е.К: Тусгай арга байхгүй. Би зүгээр л суугаад ажиллаж эхэлдэг. Хөгжим өөрөө надад юу хийхийг хэлж өгдөг. Тэгээд тодорхой үе шатанд би өөрийн гэсэн үзэл баримтлалыг бий болгож, түүнийгээ хэрэгжүүлэх чадвартай болсныхоо дараа бусад хөгжимчдийн хөгжимдлөгийг сонсож, тэднээс суралцдаг.
- М.Р: Таныг шинэ уран бүтээл дээр ажиллахад хөгжмийн зохиолчийн амьдралын нөхцөл байдал нөлөөлдөг үү?

Е.К: Тодорхой хэсгүүдийн хувьд тийм. Жишээ нь, Бетховены “Сарны сонат” гэх мэт бүтээлд шууд нөлөөлсөн. Гэсэн хэдий ч хамгийн чухал зүйл бол хөгжим өөрөө юм (Мустакимов 2021, 18) гэж хариулсан байна.

Е.Кисинтэй бид санал нийлж байгаа бөгөөд хөгжмийн ноот бичвэрт бүх зүйл тодорхой тэмдэглэгдсэн байдаг. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, хөгжмийн зохиолч өөрийн илэрхийлэх гэсэн утга санааг ноот бичвэрт тэмдэглээнүүдээр дамжуулан бичиж, тэмдэглэн үлдээсэн байдаг. Үүнийг хөгжимчин уншин хөгжимдөх үед бүх зүйл ойлгомжтой болдог. Харин хөгжимчин түүн дээр нэмээд өөрийн хөгжмийн тайлбарлалыг боловсруулгаар дамжуулан зохиолын утга санаанаас гажуудуулалгүй илэрхийлж байдаг юм.

Боловсруулгын тэмдэглээний талаар Б.Оюунбадрах “...Хөгжмийн зохиолыг боловсруулах нь зохиолыг хөгжимдөхөд бэлтгэх ажиллагаа болохын хувьд тухайн зохиолыг хэрхэн хөгжимдөх талаар тус бүрийн онцлогтой хөгжимдөх тэмдэглээнүүдийг хэрэглэдэг. Хөгжимдөх тэмдэглээ гэдэг нь тухайн зохиолыг хэрхэн хөгжимдөх талаарх ноот бичлэгийн болон үгэн хэлбэр бүхий мэдээллийг агуулсан бичлэг юм. Үүнд хурд, хүчдэл, хэллэг, хуваарилал, дуурьсуулгын талаарх тэмдэглээнүүд багтана...” (Оюунбадрах 2016, 45) гэжээ. Харин И.Т.Абрахам “...Ноот

бичвэрт нэмэлт тэмдэглээг хийх буюу хөгжмийн зэмсэг болон хөгжмийн давталтыг ажиглах, хүчдэл, хэллэг, хурдыг боловсруулснаар хөгжмийн тайлбарлалыг ихээхэн өөрчилдөг...” (Абрахам 2019, 9) гэж үзсэн байна.

Судлаач Б.Оюунбадрах, И.Т.Абрахам нарын судалгаанаас үзэхэд боловсруулга нь эх бичвэр дээрх нэмэлт тэмдэглээг юм. Бид үүнтэй санал нэг байгаа бөгөөд боловсруулгын тэмдэглээ нь хөгжимчин өөрийн ур чадвартаа нийцүүлэн нэг талаас хөгжимдөхөд эвтэй болгох, нөгөө талаас хөгжмийн тайлбарлалын дүрслэлийг биет болгон тэмдэглэж буй хэлбэр юм.

**Жишээ 1:** Ф.Жеминиани 3-р сонат, 2-р анги, 11, 12-р айзмын боловсруулгын харьцуулалт (Зураг 1)

Ж.Барбер “Ф.Жеминианийн хийлд зориулсан сонат”-ийн эхний 6 зохиолын боловсруулгыг харьцуулсан байдаг. Тус судалгаанаас нэг жишээг тодруулбал, эх хувилбар нь цэгэн тэмдэглээ буюу стаккато болон холбоостой 8 эгшгийн шудраа байдаг. Тэрээр үүнийг “particolare” гэж нэрлэдэг бөгөөд энэ нь онцгой, хэцүү техник гэсэн утгатай. Энэ хэсгийг нумын үсэрч буй хөдөлгөөнөөр хөгжимдөх нь эргэлзээтэй бөгөөд Ф.Жеминиани “нум үргэлж утсан дээр байрлах ёстой, хөгжимдөж байх үедээ нумыг дээш өргөж хөндийрүүлж болохгүй” гэж сургадаг байсан. Харин Т.Дарт үүний талаар “энэ нь стаккато-г огт хөгжимдөхгүй гэсэн үг биш, гэвч хөгжимчид эсрэгээр нь холбоостой хөгжимдөж байна...” (Барбер 1964, 23) гэж хөгжимдлөгийн ялгааны талаар харьцуулан бичсэн байгаа юм. Ф.Жеминиани энэ хэсгийн боловсруулгад стаккато тэмдэглээг оноон хөгжимдөхдөө нумыг дээш нь өргөж хөндийрүүлэхгүй гүйцэтгэнэ гэж сургасны эсрэгээр хөгжимчид холбоостой хөгжимдөж байгааг ажигласан байгаа юм. Энэ нь нэг талаас хөгжимчний боловсруулга, хөгжмийн тайлбарлал буруу хийгдсэн, нөгөө талаас ур чадвар дутуу хөгжсөнтэй холбоотой ба стаккато зөв гүйцэтгэж чадахгүй байгаатай холбоотой байж болох юм. Тиймээс хөгжимчний ур чадвар, мэдлэг чухал болох, сайтар хөгжүүлэх шаардлагатай гэдгийг энэ жишээнээс харж болохоор байна.



Зураг 1. 3-р сонат, 2-р анги, 11, 12-р айзмын боловсруулгын харьцуулалт

Л.А.Албрайт “...Орчин үеийн боловсруулгыг ихэвчлэн хөгжмийн зохиолчийн эх бичвэрт хөгжмийн тайлбарлалыг хэр сайн тусгаснаар нь үнэлдэг. Тавигдах шалгуур нь ерөнхийдөө хүчдэл, хэллэг, хэмнэл, боловсруулагчийн зөвлөмжид тусгагдсан тухайн хөгжмийг хөгжимдөх дадлагын зөв арга, мэдлэгийг агуулсан байх юм. Боловсруулагч, боловсруулгад ашигласан эх сурвалжийг тодорхойлж, эх бичвэрийг хаанаас олж болохыг хэлж өгөх, өөрийн тэмдэглээг хөгжмийн зохиолчийн эх бичвэрээс ялгаж тэмдэглэх ёстой. Сайн боловсруулга нь зохиолд гарсан аливаа томоохон өөрчлөлтийг хөгжимчинд сануулж, сэрэмжлүүлдэг...” (Албрайт 1995, 62) гэж үзсэн байна.

Энэ талаар Л.Булгакова “...Боловсруулагч нь хөгжмийн зохиолчийн бичвэрт өөрийн нэмэлт засвар, тодруулга хийдэг. Орчин үед бараг бүх хөгжмийн зохиолыг хэд хэдэн боловсруулгын хувилбараар хэвлүүлж байна. Боловсруулгыг харьцуулсан дүн шинжилгээ хийх нь тодорхой түвшний мэдлэгийг шаарддаг төдийгүй хөгжимдөх ур чадвараа хөгжүүлэхэд үр дүнтэй нөлөө үзүүлдэг бүтээлч үйл явц бөгөөд энэ нь хөгжимчний тайлбарлалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг. Энэ бүхнээс үзэхэд, хөгжимчин болон багш нарын өмнө хөгжмийн зохиолчийн хэв маягийг судалж, тухайн зохиолын утга санааг илэрхийлэхийн тулд хөгжимчний тайлбарлалыг хийж чадах уу гэсэн асуулт гарч ирж байгаа юм. Тиймээс ихэнх багш нар боловсруулагчийн тусламж хэрэгтэй гэж хүлээн зөвшөөрдөг байна...” (Булгакова 2006, 246, 248) гэжээ.

Бид судлаач Л.А.Албрайт, Л.Булгаковатай санал нийлж байгаа бөгөөд нэг зохиол дээрх боловсруулгын олон хувилбаруудаас сонгон хөгжимдөх боломжтой. Эсвэл хөгжимчин өөрийн ур чадварт нийцүүлэн боловсруулга хийж болно. Эцсийн үр дүнд хөгжмийн тайлбарлалын илэрхийлэл чухал тул үүнийг дагаад зөв боловсруулга хийх хэрэгцээ гарч ирдэг. Мөн сурагч, оюутнуудын хөгжмийн тайлбарлалыг илэрхийлэхийг багшаасаа сурч мэдэн, өөрөө бүтээлчээр ажиллан, дадлага сургуулилт хийх хугацаанд тасралтгүй хөгжсөөр байдаг бөгөөд үүнд боловсруулгын олон хувилбаруудыг хөгжимдөж, хоорондын ялгааг олж илрүүлэх нь чухал хувь, нөлөөтэй байдаг.

Хөгжимчин аливаа зохиолыг хөгжимдөхийн тулд эхлээд түүнд судалгаа хийх буюу ноот бичвэрийг уншиж, танилцсаны дараа бүтээлч үйл явцын хүрээнд дасгал сургуулилт хийдэг. Дасгал сургуулилтын үеэр ур чадвартаа тохируулан хөгжмийн илэрхийллийн аргууд буюу хуваарилал, хэллэг, хурд, хүчдэл зэргээр боловсруулга хийнэ. Үүний дараа өөрийн мэдрэмж, сэтгэл, сэтгэлгээг дамжуулах хөгжмийн тайлбарлал хамгийн сүүлд хийдэг. Эцсийн үр дүнд тухайн зохиол сонсогчдын хүртээл болдог.

Хийлийн зохиолыг боловсруулан хөгжимдөхөд хөгжмийн илэрхийллийн аргууд мөн хөгжимдөх ур чадвар салшгүй холбоотой. Энэхүү судалгаанд бид дээрх хөгжмийн илэрхийллийн аргуудаас хуваарилал болон хэллэгийг сонгон танилцуулах болно. Бидний хийлийн хуваарилал (2020а) болон хэллэгийн (2020б) тухай өгүүллэгүүдээс боловсруулах, хөгжимдөх аргыг илүү дэлгэрүүлэн үзэх боломжтой.

Хөгжмийн зохиолын боловсруулга нь нэг талаараа эх бичвэрт хөгжмийн илэрхийллийн аргуудаар дамжуулан хөгжимчинд илүү хялбар, эсвэл ур чадвараа харуулахын тулд хэцүү болгох үүднээс тэмдэглэсэн нэмэлт тэмдэглэгээнүүдийн үр дүн юм. Энэ нь хөгжимчдийн нэгнээсээ ялгаатай хөгжимдөх, хөгжимчний дотоод сэтгэлгээ, уран бүтээлч байдлыг харуулах боломжийг олгох тайлбарлалын хувилбарууд юм. Түүнчлэн, алдаа дутагдалтай гэж үзсэн эгшиг болон тэмдэглэгээг хөгжмийн утга санаанд нөлөөлөхгүйгээр өөрчилж боловсруулах боломжтой. Хөгжмийн зохиолын боловсруулга нь хөгжмийн зэмсгийн онцлогоос хамаарч боловсруулах аргын хувьд өөр өөр байдаг. Жишээ нь, төгөлдөр хуурын боловсруулгыг хэллэг, хурд, хүчдэл, хуваарилал, дуурьсуулгын аргаар илэрхийлдэг бол хийлийн боловсруулгыг хурд, хүчдэл, хуваарилалаар боловсруулах боловч

дуурьсуулга байхгүй тул нумаар хөгжимдөх арга буюу хэллэгийг илүү чухалд тооцож судалдаг.

Хийлийн зохиол дахь хуваарилал нь хөгжмийн зохиолчийн утга санааны илэрхийлэлд тулгуурлан зүүн гарын хөгжимдөх аргуудыг гарын бүтэц, хурууны даралтын хүчийг харгалзуулан оноохыг хэлнэ. Хуваарилалын гол асуудал нь хөгжмийн эгшиглэгээ болон хөгжимдөх аргыг хооронд нь уялдуулах юм.

**Жишээ 2:** “И.Брамс хийлийн концерт” 1-р анги, айзам 204-210 (Зураг 2)

Ю.Ж.Ли (2001) хуваарилалын талаар судлахдаа И.Брамсын хийлийн концертын 1-р ангид найман хөгжимчний боловсруулгыг хооронд нь харьцуулсан бөгөөд хөгжимчдийн гар хурууны бүтэц, даралтын хүч, хөгжимдөх арга, ур чадвар хоорондоо харилцан адилгүй өөр байдаг гэдгийг тодруулсан. Эдгээр найман хүн бол алдартай сурган хүмүүжүүлэгч, хийлч нар юм. Тэдний хуваарилалыг адил эсвэл хоорондоо эрс ялгаатай оноосон хэсгүүд байгааг дараах жишээнд тодруулъя.

- а) З.Франческаттийн боловсруулга нь И.Брамс хийлийн концертын 1-р ангийн зургийн жишээн дээрх хурууны хуваарилал бөгөөд хөгжимдөхөд эвтэй, амархан хуваарилалтай.
- б) Е.А.Цимбалистын боловсруулга нь боловсруулагчийн уянгын чиг баримжаа давамгайлсан байна.
- в) И.Менухины боловсруулга нь байнгын төвөгтэй хуваарилалтай бөгөөд хөгжимчин өөрийн ур чадварт нийцүүлэн хуваарилал хийсэн байна.
- г) Л.Ауэрийн боловсруулга нь сурагчдад зориулан боловсруулсан хуваарилал юм.
- д) Й.Иоахимын боловсруулга нь нэмэлт нарийн боловсруулагдсан хуваарилалтай.
- е) А.Бушын боловсруулга нь сурагч нарт зориулсан эвтэйхэн хуваарилалтай.
- ж) К.Клинглерийн боловсруулга нь хөгжимчин өөрийн ур чадварт нийцүүлэн боловсруулсан хөгжимдөхөд хэцүү хуваарилалтай байна.
- з) К.Флешийн боловсруулга нь төдийлөн нэмэлт хуваарилал тэмдэглээгүй байна.
- и) Боловсруулга нь өгүүлэл бичигчийн хуваарилал.



Зураг 2. И.Брамс хийлийн концерт 1-р анги, айзам 204-210.

б)	1	3 4	1	2 4 4(II)		0 4 4	0
в)	1	1(I)	1	1 2 3(II)	2	1	1 3 3 4 1
г)	1	1	1	2 4 4(II)		0 0	(4,0) 1
д)	1	3		4(II)4.....1		0	0 (4,0) 1
е)	1	1 3	1	2 4(II)	1	4 0 4	1
ж)	2(III) 4	1	3	2	4(II)	1	0 3 3 1
з)							
и)	1	1 3	1	2 4 4(II)	2	1	4 0 4 3 1

Хийлийн хэллэг нь нум болон гарын хөдөлгөөн, даралтын хүч, нумын хурд, нум болон утас хоорондын шүргэлцэх харилцаа холбоо бөгөөд эгшиг дээрх тэмдэглэл бүрийг хэрхэн хөгжимдөхөөс хамаарна. Хэллэг нь нумын олон аргуудаар дамжуулан өөр хоорондоо ялгаатай эгшиглээг үүсгэж байдаг.

Монголын хөгжмийн зохиолчдын хийлд зориулсан бүтээлд боловсруулга хийсэн нь нэн ховор бөгөөд МУК-ийн багш Д.Жаргалын 2007 онд хэвлүүлсэн “Монголын хөгжмийн зохиолчдын хийлд зориулсан бүтээлийн эмхэтгэл 1” ном нь хийлийн зохиол дахь боловсруулгын эхлэл гэж үзэж байна. Гэвч үүнээс цааш дэлгэрүүлж хөгжүүлсэн болон судалгаан дээр суурилсан боловсруулга одоогоор байхгүй байна.

Монголын хөгжмийн зохиолчдын хийлд зориулсан том болон жижиг хэлбэрийн бүтээлүүдээс урын санд хадгалагдан үлдсэн 18 зохиол байна. Үүнд, Г.Алтанхуяг “Хийлийн концерт”, “Концерт за цигулка и оркестр”, Б.Даваа “Аяз”, Б.Дамдинсүрэн “Хэнтийн өндөр ууланд”, Д.Дамдинжав “Сэтгэлийн дуулал хийлийн гоцлол”, Н.Жанцанноров “Хийлийн концерт”, “Романс хийлийн гоцлол”, Л.Мөрдорж “Эх орны нар хийлийн концерт”, Ц.Түмэндэмбэрэл “Казак ардын 2 дуу”, “Эх нутгаан дурсана”, “Аялгуу”, “Solo violino”, “Хараацай шувуу”, “Товийн өндөр ардын 2 дуу”, Б.Түмэнжаргал “Намрын бороо вальс”, “Цэцгийн сайхан сарнай”, “Бодол-Баяр хийлийн концерт”, Ж.Энхбаяр “Рапсоди” байна.

Дээрх бүтээлүүдээс Ж.Энхбаяр “Рапсоди”-оос бусад нь МУФ-ийн урын санд хадгалагдаж байна. УДБЭТ-ийн урын санд Б.Дамдинсүрэн “Хэнтийн өндөр ууланд”, Ж.Энхбаяр “Рапсоди” гэсэн 2 зохиол хадгалагдан үлдсэн байна. Гэвч эдгээр зохиолуудын хийлийн гоцлол хувийн ноот бичвэр байхгүй бөгөөд зөвхөн партитур болон симфони найрал хөгжмийн партууд байна. Иймд тухайн зохиолыг хэн хөгжимдөж байсан, ямар боловсруулга хийсэн гэх мэт асуудлууд гарч ирж байгаа юм. Гэвч одоог хүртэл тухайн зохиолын хөгжимдлөг болон боловсруулгын талаар судалгаа хийгдээгүй байгаа нь мөн л учир дутагдалтай байна.

**“Уран хас” бүжгэн жүжиг “Адажио” хийлийн гоцлол хувийн боловсруулга.** УДБЭТ-ийн тайзнаа тавигддаг Ж.Чулууны “Уран хас” бүжгэн жүжгийн хийлийн гоцлолд тус театрын симфони найрал хөгжмийн концертмейстер, гоцлол



хөгжимчин, удирдаач, МУУГЗ Ц.Мөнхболдын боловсруулгыг судаллаа. Ингэхдээ өгүүлэл бичигч буюу хийлч Б.Номуунаагийн боловсруулгатай харьцуулан судалсан. Тухайн зохиолын хийлийн гоцлол хувийг шивж оруулсан бөгөөд хөгжмийн зохиолч хуваарилал тэмдэглээгүй байдаг.

Ж.Чулууны “Уран хас” бүжгэн жүжиг 1973 онд нээлтээ хийсэн. Цомнолыг нь бодит явдлаас сэдэвлэн бүтээсэн бөгөөд нутагтаа “Уран” хэмээн алдаршсан Хас болон түүний дурлалт бүсгүй Хандармаа, тэдний амьдрал, хайр дурлал болоод тухайн нийгмийн байдлыг өгүүлсэн байдаг.

а хувилбар – хийлч Ц.Мөнхболдын боловсруулга

б хувилбар – хийлч Б.Номуунаагийн боловсруулгыг тус тус харьцуулав.

**Жишээ 3:** Уран хас – “Адажио” хийлийн гоцлол хувь, айзам 3-10 (Зураг 3)

а хувилбар - Ц.Мөнхболдын боловсруулгад айзам 3 болон 7-д си-гээс ре-рүү 1-р хуруугаар байрлал сольж байна. Мөн 6 ба 9-р айзмын холбоосыг салгасан байна. Ингэснээр нэг хэвийн байдлаас гарч хөгжмийн тайлбарлал болон хөгжимдөх ур чадвараа харуулах, хөгжимчний өөрийн онцлог бүхий эгшиглээг илүү тодотгон эгшиглүүлэх үүднээс холбоосыг салгасан байна. Холбоосыг салгаж хөгжимдөхөд нумын таталтыг мэдэгдэхгүй солих хэрэгтэй бөгөөд энэ нь хөгжимчний гарын даралтын хүчний хуваарилал болон сул чөлөөтэй хөдөлгөөнтэй холбоотой юм. Зүүн гарын барилыг утсан дээр байрлуулахдаа хурууны өндгийг босоо биш хэвтсэн маягтай тавьдаг. Энэ нь түүний зөөлөн, дулаахан эгшиглээний нэг шалтгаан ч байж болох юм. Ц.Мөнхболдын баруун гарын арга нь сайн хөгжсөн бөгөөд хөгжимчдийн хөгжимдөж чаддаггүй хэллэгийн аргуудыг маш эвлэгхэнээр зөв, тод эгшиглээг бий болгодог. Эдгээр нь түүний ур чадвараа байнга дээшлүүлж хөгжүүлж байдагтай холбоотой. Түүний хөгжимдөх арга, хөгжмийн тайлбарлалыг ажиглан ойлгох, мэдрэх нь хэцүү бөгөөд хүн бүрийн хүлээн авах, хүртэх мэдрэмж харилцан адилгүй тул яг энэ гэсэн барьсан тавьсан дүгнэлтэд хүрэх боломжгүй юм.

б хувилбар - Б.Номуунаагийн боловсруулгыг Ц.Мөнхболдтой харьцуулахад зарим талаараа таарахгүй байна. Үүнд айзам 3 болон 7, 10-ийн хуваарилал өөр байна. Мөн айзам 7, 9-ийн холбоос өөр байна. Энэ нь хөгжимчдийн гарын хэлбэр бүтэц, баруун зүүн гарын барил, болон хөгжимдөх арга, ур чадвар нь харилцан адилгүй байдагтай холбоотой.



Зураг 3. Уран хас – “Адажио” хийлийн гоцлол хувь, айзам 3-10.

а хувилбар – хийлч Ц.Мөнхболдын боловсруулга

1	1	2	3	1	4	2	1	3	1
		∩			∩	∩			
		v							

б хувилбар – хийлч Б.Номуунаагийн боловсруулга

3	1	2		3	1	2	1	3	3
		∩	∨			--		∩	∨

**Жишээ 4:** Уран хас – “Адажио” хийлийн гоцлол хувь, айзам 19-25 (Зураг 4)  
а хувилбар - Ц.Мөнхболдын боловсруулгад айзам 20, 23 дээр ре-г 1-р хуруугаар хөгжимдөнө гэж хуваарилсан байна. Энэ нь ре-ийн дараа хөгжимдөх фа-г 3-р хуруугаар илүү хүчтэй, тод эгшиглүүлэхэд бэлдэж байгаа хэрэг юм. 3-р хуруу нь 4-р хурууг бодвол хүчтэй бас дээд регистрийн нарийн эгшигт чичиргэл хийхэд илүү тохиромжтой, эвтэйхэн байдаг. Айзам 23, 24-т холбоосыг салгасан байна. Учир нь эхний 10 айзам гоцлол хийл, арф хөгжимтэй хоршин эгшиглэдэг бол, 19-р айзмаас хийлийн гоцлолын ард найрал хөгжим эгшиглэж байдаг. Тиймээс энэ хэсэгт хийлийн гоцлолыг тод эгшиглүүлж бусдаас ялгарах боломжийг олгохын тулд холбоосыг салгасан байна.

б хувилбар - Б.Номуунаагийн боловсруулгыг харьцуулахад хуваарилалыг адил оноосон бол хэллэгийн хувьд 25-р айзмын холбоос өөр байна. Энэ нь хөгжимчдийн баруун, зүүн гарын барил, сул чөлөөтэй хөдөлгөөн, даралтын хүчний хуваарилалаас хамаарч эвтэйхэн хөгжимдөх хувилбарыг сонгох мөн хөгжмийн тайлбарлалаас шалтгаалж боловсруулга хийдэг гэдгийг баталж байна.



Зураг 4. Уран хас – “Адажио” хийлийн гоцлол хувь, айзам 19-25

а хувилбар – хийлч Ц.Мөнхболдын боловсруулга

4		1	3		1	1		1	2	3
			∨	∩	∨	<i>non legato</i>	∩	∨	∩	∨

б хувилбар – хийлч Б.Номуунаагийн боловсруулга

4		1	3		1	1		1	2	3
			∨	∩	∨	<i>non legato</i>	∩	∨	∩	∨

**Жишээ 5:** Уран хас – “Адажио” хийлийн гоцлол хувь, айзам 26-30 (Зураг 5)  
а хувилбар - Ц.Мөнхболдын боловсруулгад холбоосуудын ихэнхийг нь салгасан байна. Учир нь найрал хөгжим 30-р айзмаас хийлийн гоцлолыг үргэлжлүүлэн гол аяыг цааш эгшиглүүлдэг. Тиймээс хийлийн гоцлолыг симфони найрал хөгжимтэй хамсран эгшиглүүлэхэд аялгууны хүчдэлийн хувьд хэт ялгарал гаргахгүй байхын тулд холбоосыг салгаж хөгжимдөх нь зүйтэй юм.

б хувилбар - Б.Номуунаагийн боловсруулгад мөн адил холбоосуудыг салгасан бөгөөд 20-р айзмын хуваарилал өөр байна. Хөгжимчин бүрийн хөгжмийн



## Дүгнэлт

Хөгжмийн зохиолч болон боловсруулагчийн тухайн ноот бичвэрт тэмдэглэсэн боловсруулгыг хөгжимчин хөгжмийн тайлбарлалаар дамжуулан амьдруулж, өөрийн ур чадварыг харуулах, дотоод мэдрэмж, сэтгэлгээгээрээ баяжуулан илэрхийлэх бүрэн боломжтой. Аливаа зохиол бүтээлийг хөгжимдөхийн өмнө ноот бичвэрт задалгаа хийн танилцсаны дараа өөрийн боловсруулгыг хийдэг бөгөөд тууштай дадлага сургуулилтын үр дүнд эгшиглэж буй шат дараалал бүхий үйл явц нь хөгжимчний бүтээлч үйл ажиллагаа юм. Боловсруулга нь бүтээлийн бүтэц, сэтгэл хөдлөлийг илэрхийлэх зорилготой хөгжмийн тайлбарлал түүнийг бүрдүүлэгч бүтээлч үйл явцын гол суурь гэж үзэж байна.

Хөгжмийн зохиолыг сонсогчдод хүргэхийн тулд хөгжимчин өөрийн мэдрэмж, сэтгэлгээнд тулгуурлан тухайн зохиолын утга санааг илэрхийлэхийн тулд хөгжимдөх аргын боловсруулгыг зайлшгүй хийсэн байдаг. Хөгжмийн хэлэнд буй эдгээр илэрхийллийн аргууд нь боловсруулгаар дамжин, хөгжимчний сэтгэлгээгээр баяжин хөгжмийн тайлбарлалыг бүрдүүлж байдаг. Энэ нь хөгжимчний хөгжимдлөгөөр дамжин хүний сэтгэлд хүрч, мэдрэгдэж буй тэрхүү мэдрэмж нь утгаа боловсруулгын аргаар дамжин хөгжимчний сэтгэлгээгээр баяжин хөгжмийн тайлбарлалыг илэрхийлж байгаа үйл явц юм.

Бид боловсруулгын талаар дараах асуудлуудыг онцолж байна.

1. Хийл хөгжимд суралцагчид болон хийлчдийн хөгжимдөж ирсэн ноотууд ихэвчлэн гадаад зохиолчдын зохиол байдаг ба ноот бичвэр дээрх олон тооны боловсруулгын хувилбар бүхий хэвлэлүүдээс сонгон хөгжимдөх боломжтой байдаг. Монголын хөгжмийн зохиолчдын хийлд зориулсан бүтээлүүдийг боловсруулсан хэвлэл нь нэн ховор бөгөөд тэдгээрийн тоо, чанарыг нэмэгдүүлэх боловсруулга хийх, хэвлүүлэх, судалгаа, уран бүтээлийн эргэлтэд оруулах хэрэгтэй.
2. Хөгжмийн зохиолчийн хөгжмийг судлан, эх бичвэрт дүн шинжилгээ хийн, хөгжмийн зэмсгийн онцлог болон хөгжимчний ур чадварт нийцүүлэн боловсруулга хийх шаардлагатай байдаг. Тиймээс боловсруулгын тухай судалж мэдэх, хөгжмийн хэвлэлд боловсруулагч болон хөгжимчний боловсруулгыг тусган хэвлүүлэхэд анхаарах, энэ чиглэлд мэргэшсэн туршлагатай боловсруулагч, хөгжимчдөөр боловсруулга хийлгэх нь манай мэргэжлийн урлагт чухал шаардлагатай байна.
3. Хөгжимчид өөрсдөө боловсруулгыг хийж зохиол бүтээл дээр тэмдэглэн үлдээдэг бөгөөд энэ нь хэвийн үзэгдэл болж хэвшсэн. Гэвч бусад оронд аль хэдийн хөгжмийн зохиолчийн эх бичвэрийг эхлээд боловсруулагчаар боловсруулж, дараа нь хөгжимчдөөр хөгжимдүүлдэг хэвшил суусан. Энэ нь бүтээлийг хурдан хугацаанд хөгжимдөж сурах, зөв гүйцэтгэлээр хөгжимдөх чанарт хүртэл шууд нөлөөлдөг. Монголын хөгжмийн зохиолчдын бүтээл мартагдах, устах аюулд хүрж болзошгүй тул түүнийг хөгжимдөхөд зориулан боловсруулга хийн хэвлүүлэх хэрэгцээ, шаардлага байна.
4. Монголын мэргэжлийн урлагийн байгууллагууд урын санд хадгалж

буй зохиолуудаа бүрэн бүтэн байлгах тал дээр анхаарал хандуулах шаардлагатай байна. Жишээ нь, УДБЭТ, МУФ-ийн урын сан дахь хадгалагдаж үлдсэн зохиолуудын хийлийн гоцлолын хувь байхгүй байна. Зөвхөн хадгалаад байх биш тухайн зохиолууд дээр боловсруулга хийн хэвлүүлэх, хөгжимчдөөр хөгжимдүүлэн эрэлт хэрэгцээнд оруулах шаардлагатай.

### Ашигласан материалын жагсаалт

#### Монгол хэлээр:

Жаргал, Д. 2007. *Монголын хөгжмийн зохиолчдын хийлд зориулсан бүтээлийн эмхэтгэл I*. Улаанбаатар.

Номуунаа, Б., Оюунбадрах, Б. 2020а. “Хийлийн зохиол дахь хуваарилалын асуудал.” *Монголын соёл урлаг судлал XXXVI*: 219-226.

Номуунаа, Б., Оюунбадрах, Б. 2020б. “Хийлийн зохиол дахь хэллэгийн асуудал.” *Монголын соёл урлаг судлал XXXVII*: 303-311.

Оюунбадрах, Б. 2016. “Төгөлдөр хуурын зохиолыг боловсруулах асуудал.” Ph.D дисс., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.

#### Гадаад хэлээр:

Благая, А. “Редакция, Обработка, Скрипка, Скрипачная азбука.” *Анна Благая* (blog). 2014. <https://blagaya.ru>.

Булгакова, Л. В. 2006. “Нотная редакция и вариантность существования музыкального произведения.” *Формирование культуры личности средствами искусства в системе классического образования (опыт междисциплинарного исследования) : по материалам Всероссийского гуманитарного форума (с международным участием) “Сибирские Афины”*: 241-250.

Abraham, I. T. 2018. “J.S.Bach’s Chaconne for Solo Violin: A Performer–Composer’s Approach to Interpretation.” Ph.D diss., The University of Arizona.

Albright, L. E. 1995. “A comparison of nine selected modern editions of the Schubert Mass in G.” Master thesis., San Jose State University.

Barber, J. J. 1964. “Practical Edition of the First Six Violin Sonatas of Opus 4 by Francesco Geminiani.” Ph.D diss., Eastman School of Music of the University of Rochester.

Ledger, T. 2020. “The performer, semiotics, and interpretation: How semiotic analysis and intention shape musical meaning and performer identity.” Ph.D diss., Schulich School of Music McGill University, Montréal.

Lee, Y. J. 2001. “An analysis of the violin concerto of Johannes Brahms.” Ph.D diss., University of Washington.

Mustakimov, T. 2021. “Mussorgsky’s pictures at an exhibition: a performer’s practical

observations on the unprecedented originality of the work.” Ph.D diss., Temple University Graduate Board.

Wiering, F., Crawford, T., & Lewis, D. 2009. “Digital Critical Editions of Music: A Multidimensional Model.” Utrecht University; Goldsmiths, University of London. 6.

УДБЭТ-ийн урын сан.

МУФ-ийн урын сан.